

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/45/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,182,557.00</u>	<u>63,486,900.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	728,100.00	252,943.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	728,100.00	16,943.00
335	Бусад авлага	-	236,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	236,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,454,457.00	63,233,957.00
351	Түүхий эд материал	106,200.00	236,200.00
35110	Тусгай зориулалттай материал	106,200.00	236,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	233,652.00	233,652.00
354	Хангамжийн материал	24,114,605.00	62,764,105.00
35410	Бичиг хэргийн материал	2,406,540.00	2,590,040.00
35420	Аж ахуйн материал	3,131,385.00	3,692,885.00
35430	Сэлбэг хэрэгсэл	561,500.00	415,000.00
35440	Түлш, шатах тослох материал	7,218,075.00	6,329,075.00
35450	Барилгын засварын материал	45,000.00	
35470	Бусад хангамжийн материал	10,752,105.00	49,737,105.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,043,442,487.11</u>	<u>1,896,829,482.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,043,442,487.11	1,896,829,482.97
392	Биет хөрөнгө	2,025,624,905.23	1,879,163,085.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,702,072.74	796,302,372.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	(92,117,576.59)	(144,229,834.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,540,893.00	147,540,893.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(132,737,720.00)	(135,558,345.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	365,878,334.00	369,478,334.00

39206	Хуримтлагдсан элэгдэл	(296,443,133.86)	(310,536,021.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,593,994.00	33,993,994.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,306,040.19)	(21,615,192.13)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,598,557,573.20	1,648,457,573.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	(447,729,230.20)	(622,905,480.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	205,728,844.00	254,728,844.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(109,043,104.87)	(136,494,053.15)
393	Биет бус хөрөнгө	17,817,581.88	17,666,397.95
39301	Програм хангамж	1,883,400.00	1,883,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(732,300.12)	(883,484.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,666,482.00	16,666,482.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,068,625,044.11</u>	<u>1,960,316,382.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>843,159.00</u>	<u>6,481,075.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	843,159.00	6,481,075.00
413	Өглөг	843,159.00	6,481,075.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	762,759.00	6,274,540.00
4136	Бусад өглөг	80,400.00	206,535.00
41361	Байгууллагад төлөх өглөг		126,135.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	80,400.00	80,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,067,781,885.46</u>	<u>1,953,835,307.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,067,781,885.46	1,953,835,307.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	850,148,776.35	850,148,776.35
51101	Өмч: - төрийн	850,148,776.35	850,148,776.35
512	Хуримтлагдсан үр дүн	341,333,021.17	227,386,443.68
51210	Өмнөх үеийн үр дүн	341,333,021.17	341,333,021.17
51220	Тайлант үеийн үр дүн		(113,946,577.49)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	876,300,087.94	876,300,087.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,068,625,044.46</u>	<u>1,960,316,382.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	558,480,561.00	537,972,272.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	59,450,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	59,450,300.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	59,450,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	59,450,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	558,480,561.00	478,521,972.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,929,993.00	101,900,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	13,929,993.00	101,900,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,608,328.00	3,851,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,608,328.00	1,219,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,632,491.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	535,942,240.00	372,770,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	535,942,240.00	372,770,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	755,529,780.52	651,918,849.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	755,529,780.52	651,918,849.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,921,540.52	651,098,274.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,499,944.00	266,621,293.00
210101	Үндсэн цалин	268,922,456.00	266,621,293.00
210104	Урамшуулал	577,488.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,890,345.00	34,958,110.00
210201	Тэтгэврийн даатгал	33,890,345.00	34,958,110.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,201,068.00	19,330,745.00
210301	Гэрэл, цахилгаан	1,310,700.00	2,645,745.00
210302	Түлш, халаалт	16,890,368.00	16,685,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,127,374.28	19,780,990.00

210401	Бичиг хэрэг	4,424,205.00	2,089,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,106,244.00	15,789,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,516,400.00	1,902,350.00
210404	Ном, хэвлэл	276,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,804,225.28	-
2105	Нормативт зардал	500,500.00	139,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,500.00	139,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,718,400.00	2,134,365.00
210602	Тавилга	1,023,400.00	-
210604	Урсгал засвар	695,000.00	2,134,365.00
2107	Томилолт, зочны зардал	3,919,800.00	4,458,000.00
210702	Дотоод албан томилолт	3,919,800.00	4,458,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,509,768.00	798,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,000.00	135,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,400.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,080.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	421,300.00	109,500.00
210807	Газрын төлбөр	45,600.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,188.00	8,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	362,554,341.24	302,876,871.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,074,000.00	28,377,567.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	386,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	272,480,341.24	274,113,304.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,608,240.00	820,575.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,815,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,815,200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	793,040.00	820,575.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	793,040.00	820,575.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(197,049,219.52)	(113,946,577.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(197,049,219.52)	(113,946,577.49)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	850,148,776.35	876,300,087.94	341,333,021.17	2,067,781,885.46
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	850,148,776.35	876,300,087.94	341,333,021.17	2,067,781,885.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	850,148,776.35	876,300,087.94	341,333,021.17	2,067,781,885.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-113,946,577.49	-113,946,577.49
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	850,148,776.35	876,300,087.94	227,386,443.68	1,953,835,307.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	526,687,628.00	376,621,972.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,687,628.00	376,621,972.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,608,328.00	3,851,672.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,608,328.00	1,219,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,632,491.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	518,079,300.00	372,770,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	518,079,300.00	372,770,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>475,967,628.00</u>	<u>371,621,972.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>475,967,628.00</u>	<u>371,621,972.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>444,359,388.00</u>	<u>370,801,397.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,171,888.00	259,121,700.00
210101	Үндсэн цалин	180,766,900.00	185,768,435.00
210102	Нэмэгдэл	59,577,323.00	52,074,529.00
210104	Урамшуулал	577,488.00	
210105	Гэрээт ажлын хөлс	22,250,177.00	21,278,736.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,626,600.00	35,058,808.00
210201	Тэтгэврийн даатгал	25,307,700.00	23,814,008.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,579,700.00	3,561,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,063,800.00	2,048,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	515,900.00	512,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,159,500.00	5,122,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,192,564.00	19,779,817.00
210301	Гэрэл, цахилгаан	1,310,700.00	2,645,745.00
210302	Түлш, халаалт	16,881,864.00	17,134,072.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,184,340.00	15,760,600.00
210401	Бичиг хэрэг	2,232,900.00	2,375,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,104,540.00	11,454,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,814,500.00	1,842,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,400.00	88,000.00
2105	Нормативт зардал	304,600.00	457,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	304,600.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,500.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	250,500.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,919,800.00	4,360,000.00
210702	Дотоод албан томилолт	3,919,800.00	4,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,703,700.00	1,311,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,000.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,400.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,100.00	437,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	104,800.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,005,396.00	33,851,672.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,005,396.00	33,351,672.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,608,240.00	820,575.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,815,200.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,815,200.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	793,040.00	820,575.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	793,040.00	820,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,720,000.00	5,000,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50,720,000.00	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,720,000.00	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,720,000.00	5,000,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,720,000.00	5,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(50,720,000.00)	(5,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,770,300.00	371,949,725.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,770,300.00	371,949,725.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,770,300.00	371,949,725.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,121,700.00	259,121,700.00
210101	Үндсэн цалин	184,586,700.00	184,586,700.00
210102	Нэмэгдэл	51,850,900.00	52,074,529.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,684,100.00	22,460,471.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,576,500.00	35,576,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,331,700.00	24,331,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,561,300.00	3,561,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,048,900.00	2,048,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	512,200.00	512,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,122,400.00	5,122,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,791,500.00	19,262,125.00
210301	Гэрэл, цахилгаан	2,284,700.00	2,128,053.00
210302	Түлш, халаалт	17,506,800.00	17,134,072.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,874,600.00	15,760,600.00
210401	Бичиг хэрэг	2,375,400.00	2,375,800.00
210402	Тээвэр, шатахуун	11,454,800.00	11,454,800.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,956,400.00	1,842,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	88,000.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,212,500.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,212,500.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,380,700.00	4,360,000.00
210702	Дотоод албан томилолт	4,380,700.00	4,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,355,800.00	1,311,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,400.00	150,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	302,200.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,900.00	168,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	437,700.00	437,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	80,000.00	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,000,000.00	35,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,500,000.00	34,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	372,770,300.00	371,949,725.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	372,770,300.00	371,949,725.00
132001	Орон нутгийн төсвөөс	372,770,300.00	371,949,725.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28

620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,851,672.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,851,672.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,851,672.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,851,672.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,851,672.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,851,672.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,851,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,219,181.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,632,491.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Булган Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 3/27 дугаар албан бичгээр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Булган сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажил, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллана. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2019, 2020 оны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд шалгалт хийсэн байна.

ЗДТГ нь дотоод хяналтын нэгжтэй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 755.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108.3 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	728.1	252.9	(475.2)
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	24,454.5	63,233.9	38,779.5
Үндсэн хөрөнгө	2,043,442.5	1,896,829.5	(146,613.0)
Нийт хөрөнгө	2,068,625.0	1,960,316.4	(108,308.7)

Өр төлбөр	843.2	6,481.1	5,637.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,067,781.9	1,953,835.3	(113,946.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,068,625.0</u>	<u>1,960,316.4</u>	<u>(108,308.7)</u>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансанд оны эхэнд энгийн ашгийн 0.2 сая, тээвэр шатахууны 0.1 сая, урьдчилгааны 0.4 сая, нийт 0.7 сая төгрөгийн авлагатай байснаас 0.5 сая төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст томилолтын 0.1 сая, бараа материалын 0.2 сая, 0.3 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63.2 сая төгрөг болж 38.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 38.9 сая төгрөгийн өвс, тэжээлийг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс үнэ төлбөргүй хүлээн авч, 41.4 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч үйл ажиллагаандаа 41.5 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,896.8 сая төгрөг болж 146.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 5.0 сая, 20.6 сая төгрөгийн үнэ бүхий багийн конторын барилгыг хувь хүнээс үнэ төлбөргүй хандиваар, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 28.9 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилтээр гүүрийн засвар, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 73.0 сая төгрөгийн санхүүжилтээр хадлангийн талбай хаших, гүүр барих, шуудууны эх гаргах ажлуудыг орлогод авсан нийт 127.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 274.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эхэнд цалингийн ашигт 0.87 сая, хувь хүмүүст өгөх 0.05 сая, нийт 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Оны эцэст цалингийн ашигт 6.3 сая, тээвэр шатахууны зардлын 0.1 сая, хувь хүмүүст өгөх 0.05 сая, нийт 6.5 сая төгрөгийг өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,953.8 сая төгрөг болж 113.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 113.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 537.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 20.5 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт болон хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 103.6 сая төгрөгөөр буюу 30 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт хангамж, бараа материалын болон бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант онд нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 337.3 сая төгрөг, тодотгосон төсөв 372.6 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 35.4 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.

Булган сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 17ны өдрийн 20 дугаар тогтоолоор орон нутгийн орлогын давсан орлогоос ЗДТГ-т 35.5 сая төгрөгийг хуваарилаж баталсан байна.

Цалингийн зардлыг 3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 1 сая, гэрэл цахилгааны зардлыг 1 сая, бараа үйлчилгээний зардлыг 32.5 сая, нийт 37.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, томилолт, шуудан холбооны зардлыг анх баталсан төсвөөс 2.0 сая төгрөгөөр бууруулж нийт дүнгээр төсвийг 35.5 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд 372.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 371.8 сая төгрөгийг зарцуулж, 0.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж тогтмол зардлыг 0.5 сая, хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засвар томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудыг 0.3 сая буюу нийт 0.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт төсвийн 70 хувийг цалин, 9.5 хувийг НДШ-ийн зардал, 5.1 хувийг тогтмол зардал, 9.4 хувийг бараа үйлчилгээний зардал, 6 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2.6 сая төгрөгийн, нийт 3.8 сая төгрөгийн орлого хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд 3.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлээр нийтдээ 371.8 сая төгрөгийн төсөв зарцуулснаас байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад

тэвчиж болох урсгал зардал 58.1 сая төгрөгийн төсвийн 10 хувиар 5.8 сая төгрөгөөр хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Булган Засаг даргын тамгын газрын 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 89 мэдээллийг хугацаандаа оруулсан, 28 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн 3-р улирлын мэдээг хугацаа хоцроож оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 208.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг оруулаагүй, 0.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн 3 шийдвэр, 6.5 сая төгрөгийн өр үүсгэсэн 3 шийдвэрийг байршуулаагүй, тайлант оны шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 50 хувьтай байгаа ба өмнөх онд шилэн данстай холбоотой зөвлөмж авсан боловч тул тайлант онд зөрчлийг арилгаж ажиллаагүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түлш халаалтын зардлаас худалдан авсан 0.9 сая төгрөгийн нүүрс, модыг бараа материалын дансанд орлогод аваагүй, мөн гэрэл цахилгаан, шуудан холбоо, томилолт, бараа үйлчилгээний бусад зардлуудад зарцуулсан 96.2 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 19.3 сая төгрөгийн 3 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байсан зөрчлүүдэд зөвлөмж өгөгдсөн.

Зөвлөмжийн биелэлтийг Булган сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 323 тоот албан бичигээр ирүүлсэн байна. Тайлант оны байдлаар хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тайлант онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангагдсан эсэхийг анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1120.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1116.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 1116.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 371.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлын батлагдсан төсөв 58.1 сая төгрөгийн 10 хувь буюу 5.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллах ёстойгоос 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн ба 5.5 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

"Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож,

урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасны дагуу хэмнэж зарцуулаагүй 5.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

1. Булган сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайланд тусгагдсан 805.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 62.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, хөрөнгийн үлдэгдэлийг тооцоо хийж баталгаажуулаагүй байна.

2. Тайланд хугацааны цалин, тээвэр шатахуун, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн данс, бараа үйлчилгээний бусад зардлын нийт 21.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийн журналуудыг бүрэн хөтлөөгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.3 “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.2 “журналд бичих”, 14.3.3 “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5 “бүх орлого”, 14.4.6 “бүх зардал”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”, 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө, бараа материалын тооллогыг хуулинд заасан хугацаанд хийх, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийн журналуудыг бүрэн хөтлөх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж ажиллах талаар 3353.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

3. Шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн 3 дугаар улирлын мэдээг хугацаа хоцроож оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 208.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг оруулаагүй, 0.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн 3 шийдвэр, 6.5 сая төгрөгийн өр үүсгэсэн 3 шийдвэрийг байршуулаагүй өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргажээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул зөрчлийг арилгуулах талаар 220.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Гэрэл цахилгааны зардлаас 0.5 сая, түлш халаалтын зардлаас 0.1 сая, хангамж, бараа материалын зардлаас 0,4 сая, нормативт зардлаас 0.1 сая, эд хүгшил, урсгал засварын зардлаас 0.8 сая, томилолтын зардлаас 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлуудаас 0.1 сая, нийт 2.1 сая төгрөгийг цалингийн зардалд, түлш халаалтын зардлаас 1.3 сая төгрөгийн тээвэр шатахууны зардалд, хичээл практикийн зардлаас гэрэл цахилгааны зардалд 0.1 сая буюу нийт 3.5 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулжээ.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэн”, 42.3.1-д “төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, хүргүүлэх” гэсэн заалтыг баримталж, зөрчлийг арилгаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү..

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын Засаг даргын тамгын газар	3	1120.1					2	1116.6	1	3.5